



**“ТӨРӨӨС ЯВУУЛЖ БУЙ БОДЛОГЫН ТАЛААРХ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ”
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**



Улаанбаатар

2023 он



“ТӨРӨӨС ЯВУУЛЖ БУЙ БОДЛОГЫН ТАЛААРХ ХАН-УУЛ ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ”

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны тайлан хянасан: О.Гэрэл /Хан-Уул дүүргийн Статистикийн хэлтсийн дарга/

Судалгааны тайлан бичсэн: Б.Тодмаа / Хан-Уул дүүргийн Статистикийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн/

З.Сайнзаяа / Хан-Уул дүүргийн Статистикийн хэлтсийн
мэргэжилтэн/

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХУД	Хан-Уул дүүрэг
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
ХАӨМС	Хүн ам, өрхийн мэдээллийн сан

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	4
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	6
1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО	6
1.2 ХАМРАХ ХҮРЭЭ	6
1.3 ТҮҮВРИЙН НЭГЖ	6
1.4 СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ	6
1.4.1 Судалгааны үр дүнг тархаах түвшин	6
1.4.2 Түүврийн хэмжээг тодорхойлох	6
1.4.3 Түүврийн үе шат	8
1.4.4 Түүврийн жин	8
1.5. СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ	8
1.6. СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ	8
ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН.....	9
2.1 СУДАЛГААНЫ ХАМРАЛТ	9
2.2 ХҮН АМ ЗҮЙН ШИНЖ БАЙДАЛ.....	9
2.3 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ.....	13
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ	15
3.1 БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ	15
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРҮҮЛ МЭНД	19
4.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ.....	19
ТАВДУГААР БҮЛЭГ. АМЬДАРЧ БУЙ ОРЧИН.....	23
5.1 АМЬДАРЧ БУЙ ОРЧНЫ ТАЛААРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ	23
ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХОГ ХАЯГДАЛ.....	26
6.1 ХОГ ХАЯГДЛЫН ТАЛААРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ.....	26
ДОЛООДУГААР БҮЛЭГ. ХОРООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	28
7.1 ХОРООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ	28
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	33
ХАВСРАЛТ А.....	35
ХАВСРАЛТ Б.....	41

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. СУДАЛГААНЫ ТҮҮВРИЙН ХУВААРИЛАЛТ, ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ХОРООГООР	7
ХҮСНЭГТ 2. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ХҮН АМЫН ТОО, ХОРООГООР, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2023 ОН	9
ХҮСНЭГТ 3. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2023 ОН	12
ХҮСНЭГТ 4. АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ҮНДСЭН ШАЛТГААН, ТӨРЛӨӨР, ХУВИАР, 2023 ОН	14
ХҮСНЭГТ 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ	19
ХҮСНЭГТ 6. НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ	20
ХҮСНЭГТ 7. ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙДАЛ, ХУВИАР	26
ХҮСНЭГТ 8. ХОРООДЫН АЛБАН ХААГЧДАД ӨГСӨН ҮНЭЛГЭЭНИЙ ЭЗЛЭХ ХУВЬ	28
ХҮСНЭГТ 9 НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ӨГСӨН ҮНЭЛГЭЭНИЙ ЭЗЛЭХ ХУВЬ	31

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. ХАН- УУЛ ДҮҮРГИЙН ХҮН АМ НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2023 ОН	10
ЗУРАГ 2. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2022 ОН	10
ЗУРАГ 3. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ӨРХИЙН ТОО, 2023 ОН	11
ЗУРАГ 4. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН БАЙРШИЛ, ХОРООГООР, 2023 ОН	11
ЗУРАГ 5. АМЬДАРЧ БУЙ ОРЧНЫ СУУЦНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХУВИАР, 2023 ОН	12
ЗУРАГ 6. 18 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХУВИАР, 2023 ОН	13
ЗУРАГ 7. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХУВЬ, 2023 ОН	13
ЗУРАГ 8. ХАН-УУЛ ДҮҮРЭГТ АМЬДАРЧ БУЙ ХУГАЦАА, ХУВИАР, 2023 ОН	15
ЗУРАГ 9. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СҮҮЛИЙН 3 ЖИЛД ХЭРЭГЖСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛУУДЫГ НЭРЛЭСЭН БАЙДАЛ, ХУВИАР, 2023 ОН	15
ЗУРАГ 10. АМЬДАРЧ БУЙ ОРЧИНД ТОГЛООМЫН ТАЛБАЙ БАЙДАГ ЭСЭХ, ХУВИАР, 2023 ОН	16
ЗУРАГ 11. ТОГЛООМЫН ТАЛБАЙ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БАЙРШИЛ, ХУВИАР	16
ЗУРАГ 12. ГЭРЭЛТҮҮЛЭГ НЭМЭХ БАЙРШИЛ, ХУВИАР	17
ЗУРАГ 13. АМЬДАРЧ БУЙ ОРЧИНД ГЭРЭЛТҮҮЛЭГ БАЙДАГ ЭСЭХ, ХУВИАР	17
ЗУРАГ 14. ГЭРЭЛТҮҮЛГИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ, ХУВИАР	17
ЗУРАГ 15. ИРГЭДИЙН АЯ ТУХТАЙ АМРАХ ТАЛБАЙГ ЭСЭХ ТАЛБАЙГ НЭМЭГДҮҮЛСЭН АЖЛУУД	18
ЗУРАГ 16. ИРГЭДИЙН АЯ ТУХТАЙ АМРАХ НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛЫН ТАЛААР МЭДДЭГ ХҮРТЭЭМЖТЭЙ ЭСЭХ, ХУВИАР	18
ЗУРАГ 17. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨР ҮЙЛЧИЛГЭЭ АВАХАД ХЭР ЗЭРЭГ ХҮНДРЭЛ УЧИРСАН ЭСЭХ, ХУВИАР	19
ЗУРАГ 18. НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХҮНДРЭЛТЭЙ ЭСЭХ, ХУВИАР	20
ЗУРАГ 19. ӨРХИЙН ЭМНЭЛГЭЭР ҮЙЛЧЛҮҮЛДЭГ ЭСЭХ, ХУВИАР	21

ЗУРАГ 20. ӨРХИЙН ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХҮНДРЭЛТЭЙ ЭСЭХ, ХУВИАР	21
ЗУРАГ 21. ЭРҮҮЛ МЭНДИЙГ ҮЙЛЧИЛГЭЭГ АВСАН ЭСЭХ, ХУВИАР	21
ЗУРАГ 22. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМААР ЦАГ ҮЗҮҮЛЖ ЧАДДАГ ЭСЭХ, ХУВИАР	21
ЗУРАГ 23. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЭРТ ИЛРҮҮЛЭХ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ, ОНОШИЛГООНД ХАМРАГДСАН ЭСЭХ, ХУВИАР	22
ЗУРАГ 24. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭХ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ ОНОШИЛГООНЫ МЭДЭЭЛЭЛ АВСАН ЭХ ҮҮСВЭР, ХУВИАР	22
ЗУРАГ 25. АМЬДАРЧ БУЙ ГАЗАР СӨХ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ЭСЭХ, ХУВИАР	23
ЗУРАГ 26. СӨХ -ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ТАЛААР ИРГЭДЭЭС САНАЛ АВДАГ БАЙДАЛ,	23
ЗУРАГ 27. АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДАРЧ ЧАДАЖ БУЙ ЭСЭХ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР	24
ЗУРАГ 28. ХЭРЭГЛЭЭНИЙ УСНЫ ЧАНАР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР	24
ЗУРАГ 29. АМЬДАРЧ БУЙ ГАЗРЫН ОЙР ОРЧИМ ДУУ ЧИМЭЭТЭЙ ЭСЭХ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР	24
ЗУРАГ 30. АМЬДАРДАГ ГАЗРЫН ОЙРОЛЦООХ ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛИЙН ХҮРТЭЭМЖ, ХУВИАР	25
ЗУРАГ 31. АМЬДАРЧ БУЙ ГАЗРЫН ОЙР ОРЧИМ ЦЭВЭР, ХУГАЦААНДАА ХОГОО АЧДАГ БАЙДАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР	26
ЗУРАГ 32. АМЬДАРЧ БУЙ ГАЗРЫН ОЙР ОРЧМЫН ЗАМ ТАЛБАЙ ЗАСВАРЛАХ АЖИЛД ӨГЧ БУЙ ҮНЭЛГЭЭ, ХУВИАР	27
ЗУРАГ 33. ДҮҮРЭГ, ХОРООТОЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ ХҮССЭН МЭДЭЭЛЛЭЭ АВЧ, САНАЛ ХҮСЭЛТЭЭ АВЧ ЧАДДАГ ЭСЭХ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР	27
ЗУРАГ 34. ХОРООГООР ҮЙЛЧЛҮҮЛЖ БАЙСАН ЭСЭХ, ХУВИАР	28
ЗУРАГ 35. ХОРООНООС ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ НЭГ ДОР АВЧ ЧАДАЖ БАЙГАА ЭСЭХ, ХУВИАР	28
ЗУРАГ 36. ХОРООГООР ҮЙЛЧЛҮҮЛДЭГ ШАЛТГААН, ХУВИАР	29
ЗУРАГ 37. ХОРООНООС ҮЙЛЧИЛГЭЭ АВАХАД ТУЛГАРСАН ХҮНДРЭЛ, ХУВИАР	29
ЗУРАГ 38. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМААР АВЧ ЧАДАЖ БАЙГАА БАЙДАЛ, ХУВИАР	30
ЗУРАГ 39. ДҮҮРГИЙН АМРАЛТЫН ГАЗАР, ЖУУЛЧНЫ БААЗ, ЗОЧИД БУУДЛУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ, ХУВИАР	30
ЗУРАГ 40. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ АЖЛЫН САНАЛ, ХУВИАР	30
ЗУРАГ 41. ДҮҮРГИЙН НЭГ ЦЭГЭЭР ҮЙЛЧЛҮҮЛЖ БАЙСАН ЭСЭХ, ХУВИАР	31
ЗУРАГ 42. ХУРДАН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГЭЭР ҮЙЛЧЛҮҮЛЖ БАЙСАН ЭСЭХ, ХУВИАР	32
ЗУРАГ 43. ДҮҮРГЭЭС ЯВУУЛЖ БУЙ БОДЛОГО ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭН АВДАГ ЭХ ҮҮСВЭР, ХУВИАР	32
ЗУРАГ 44. ДҮҮРГЭЭС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ САНАЛ, ХУВИАР	32

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хан-Уул дүүргийн иргэдээс төрийн байгууллагын үйлчилгээ, дүүргээс хэрэгжүүлж байгаа бодлого, бүтээн байгуулалт, тохижилтын ажлын талаарх сэтгэл ханамжийн байдлын үнэлгээ, хандлагыг үнэлэх судалгааг дүүргийн хэмжээнд зохион байгууллаа. Судалгааг Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын захиалгаар Статистикийн хэлтэс хороодын албан хаагчидтай хамтран зохион байгуулж, мэдээллийг цуглуулан, нэгдсэн үр дүнг тооцон гаргалаа.

1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Энэхүү судалгаагаар төрөөс явуулж буй бодлого, төрийн байгууллагын үйлчилгээ, Хан-Уул дүүргээс хэрэгжүүлж буй бүтээн байгуулалт, тохижилтын ажлын гүйцэтгэлийн талаарх иргэдийн сэтгэл ханамж, бодлогын хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлохыг зорилго.

1.2 ХАМРАХ ХҮРЭЭ

Судалгааны хамрах хүрээ зөвхөн Хан-Уул дүүрэгт оршин суугчдыг хамрах бөгөөд Хан-Уул дүүрэгт амьдардаг боловч бүртгэлгүй болон бүртгэлтэй боловч тухайн дүүрэгт амьдрахгүй байгаа хүмүүс судалгааны хүрээнээс гадуур байх юм.

1.3 ТҮҮВРИЙН НЭГЖ

Судалгааны мэдээлэл цуглуулалтын түүврийн нэгж нь Хан-Уул дүүрэгт амьдарч буй 18-аас дээш насны Монгол Улсын иргэн байна.

1.4 СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ

1.4.1 Судалгааны үр дүнг тархаах түвшин

Судалгааны үр дүнг Хан-Уул дүүргийн түвшинд болон хороодын түвшинд төлөөлөх чадвартай байхаар боловсруулсан.

1.4.2 Түүврийн хэмжээг тодорхойлох

Тодорхой нэг нутаг дэвсгэр эсвэл хүн амын тодорхой бүлгийн хувьд 1 үе шаттай түүвэр судалгааны түүврийн хэмжээг дараах томъёоллын дагуу тооцно. Үүнд:

$$n = \frac{Z^2 \times P_0 \times (1 - P_0)}{e^2 \times rr} \quad (1)$$

Дээрх томъёоллын дагуу түүврийн хэмжээг тодорхойлохын тулд эхлээд өгөгдсөн хувьсагчдын утгыг тодорхойлно. Үүнд:

- z – 95 хувийн ач холбогдлын түвшин дэх t статистикийн тархалтын утга **1.96**
- P_0 – түлхүүр үзүүлэлтийн хувийн жин. (Өмнө нь ижил төрлийн судалгаа явж байгаагүй үед болон тодорхой төсөөлөл байхгүй үед **=0.50**)
- e – таамаглаж байгаа алдааны хязгаарыг аль болох бага хэмжээтэйгээр авах бөгөөд практикт 5-15 хувийн харьцангуй алдаатай байхад судалгааны үр дүнг ашиглаж болдог. (Бидний тохиолдолд таамаглаж байгаа харьцангуй алдаа 15 % буюу абсолют алдаа **3.7** хувь)
- rr – судалгаанд 10 хүн тутмын нэг буюу 10 хувь нь ямар нэгэн шалтгаанаар хариулахгүй байна гэж үзсэн.

Хувьсагчдын утгыг дээрх байдлаар тодорхойлж, түүврийн хэмжээг тооцоход нэг хороог төлөөлөх түүврийн хэмжээ 190 болж байна. Хан-Уул дүүрэг нь нийт 25 хороотой тул түүврийн хэмжээ 4750 хүн болно.

ХҮСНЭГТ 1. СУДАЛГААНЫ ТҮҮВРИЙН ХУВААРИЛАЛТ, ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ХОРООГООР

Хороо	2022 оны хүн амын тоо	Түлхүүр үзүүлэлтийн хувь	Хамрагдалтын хувь	Түүврийн хэмжээ
1-р хороо	11,605	0.5	90	190
2-р хороо	13,575	0.5	90	190
3-р хороо	15,285	0.5	90	190
4-р хороо	6,283	0.5	90	190
5-р хороо	4,964	0.5	90	190
6-р хороо	7,194	0.5	90	190
7-р хороо	4,497	0.5	90	190
8-р хороо	11,109	0.5	90	190
9-р хороо	8,735	0.5	90	190
10-р хороо	9,918	0.5	90	190
11-р хороо	9,943	0.5	90	190
12-р хороо	5,913	0.5	90	190
13-р хороо	3,851	0.5	90	190
14-р хороо	5,988	0.5	90	190
15-р хороо	16,721	0.5	90	190
16-р хороо	8,542	0.5	90	190
17-р хороо	13,812	0.5	90	190
18-р хороо	10,950	0.5	90	190
19-р хороо	15,860	0.5	90	190
20-р хороо	9,583	0.5	90	190
21-р хороо	10,739	0.5	90	190
22-р хороо	7,774	0.5	90	190
23-р хороо	5,124	0.5	90	190
24-р хороо	12,476	0.5	90	190
25-р хороо	8,070	0.5	90	190
Нийт	225,205	0.5	90	4750

1.4.3 Түүврийн үе шат

Түүвэрлэлт хийх үйл ажиллагаа нь 1 үе шаттай бөгөөд хороо бүрээс төлөөлөх чадвар бүхий иргэнийг магадлалт санамсаргүй түүврийн аргаар сонгосон.

1.4.4 Түүврийн жин

Үр дүнгийн тооцоо хийх, дүн шинжилгээ боловсруулахад түүврийн жинг тооцож ашиглана. Түүврийн жинг тооцоход дараах тоо мэдээлэл шаардлагатай. Үүнд:

Түүврийн жин нь тухайн шатанд сонгогдсон элементүүдийн магадлалын урвуу хэмжигдэхүүн байх бөгөөд дараах байдлаар тооцно:

$$W_{1k} = \frac{A_k}{A_{ks}}$$

A_k = k дугаар бүлгийн нийт хүний тоо

A_{ks} = k дугаар бүлгээс сонгогдсон s ширхэг иргэний тоо

1.5. СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

Судалгааны мэдээллийг цахимаар цуглуулахаар Кобо программ дээр асуулгыг судалгаанд оролцогч өөрөө нөхөх, судлаач оролцогчоос утсаар мэдээллийг авч нөхөх байдлаар боловсруулсан. Шаардлагатай нөхцөлд судалгааг сонгогдсон иргэнээс гэрийн хаягаар очиж, маягтаар авах боломжтой.

Судалгааг 25 хороодын зохион байгуулагч, хэсгийн ахлагч нар 2023 оны 6 сарын 23-ны өдрөөс 7 сарын 03-ны өдрийг дуусталх хугацаанд явуулж, хороо бүрээс 190 хүн, нийт 4650 хүнээс судалгааны мэдээллийг цуглуулсан. Судалгааны мэдээллийг түүврээр сонгогдсон иргэнээс асуулгын дагуу бүрэн гүйцэд цуглуулж байгаа эсэхэд Статистикийн хэлтсийн албан хаагчид хороодод хяналт тавьж, хамтран ажилласан.

1.6. СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Статистикийн хэлтсээс хороодоос цуглуулсан судалгааны мэдээллийг (Кобо программ дээр) , боловсруулж, өгөгдлийг цэвэрлэж, нэгтгэсэн. Кобо программ дээр нэгтгэсэн мэдээллийг SPSS судалгааны программ руу хөрвүүлж, анхдагч мэдээллийн уялдааг шалгах, үр дүнгийн хүснэгт боловсруулах, статистик дүн шинжилгээ хийх, судалгааны үр дүнгийн тайланг бичих ажлуудыг хийлээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

2.1 СУДАЛГААНЫ ХАМРАЛТ

Судалгааны хамрагдалтын түвшинг авч үзэхэд Хан-Уул дүүргийн хэмжээний 238511 хүн амыг төлөөлөхүйц 4784 хүн амыг судалгаанд хамруулсан.

2.2 ХҮН АМ ЗҮЙН ШИНЖ БАЙДАЛ


Судалгаанд Хан-Уул дүүрэгт амьдарч буй 18-аас дээш насны Монгол Улсын иргэн хамрагдсан. Үүнд 43.8 хувь нь эрэгтэйчүүд, 56.8 хувь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 2. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ХҮН АМЫН ТОО, ХОРООГООР, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2023 ОН

Хороо	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
Бүгд	238 511	104 526	133 985	78.0
1-р хороо	11 605	4 886	6 719	72.7
2-р хороо	13 575	5 081	8 494	59.8
3-р хороо	15 285	6 227	9 058	68.8
4-р хороо	6 283	2 974	3 309	89.9
5-р хороо	4 964	2 634	2 330	113.1
6-р хороо	7 194	3 288	3 906	84.2
7-р хороо	4 497	1 916	2 581	74.3
8-р хороо	11 109	4 962	6 147	80.7
9-р хороо	8 735	4 230	4 505	93.9
10-р хороо	9 918	4 667	5 251	88.9
11-р хороо	9 943	3 820	6 123	62.4
12-р хороо	5 913	3 129	2 784	112.4
13-р хороо	3 851	1 974	1 877	105.2
14-р хороо	5 988	2 865	3 123	91.8
15-р хороо	16 721	7 934	8 787	90.3
16-р хороо	8 542	4 020	4 522	88.9
17-р хороо	13 812	7 051	6 761	104.3
18-р хороо	10 950	4 447	6 503	68.4
19-р хороо	15 860	7 163	8 697	82.4
20-р хороо	9 583	3 290	6 293	52.3
21-р хороо	10 739	4 250	6 489	65.5
22-р хороо	7 774	3 069	4 705	65.2
23-р хороо	5 124	2 268	2 856	79.4
24-р хороо	12 476	5 110	7 366	69.4
25-р хороо	8 070	3 270	4 800	68.1


Эдгээр иргэдийг хүйс болон хороогоор авч үзэхэд Хан-Уул дүүргийн 5, 12,13, 17 хороодын эрэгтэйчүүд судалгаанд хамгийн их хамрагдсан бол бусад хороодын хувьд эмэгтэйчүүд давамгайлж байна (Хүснэгт 2).

ЗУРАГ 1. ХАН- УУЛ ДҮҮРГИЙН ХҮН АМ НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2023 ОН




Хан-Уул дүүргийн хүн амыг хүйсээр авч үзвэл бүх насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд эрэгтэйчүүдтэй харьцуулахад 1.0-2.1 дахин байгаа нь дээрх зургаас харагдаж байна (Зураг 1). Насны бүлгээр авч үзэхэд 18-27 насны иргэд 34457 буюу 14.4 хувь, 28-37 насны иргэд 70026 буюу 29.4 хувь, 38-47 насны иргэд 53423 буюу 22.4 хувь, 48-57 насны иргэд 39785 буюу 16.7 хувь, 58-67 насны иргэд 26231 буюу 11.0 хувь, 68-аас дээш насны иргэд 14589 буюу 6.1 хувийг тус тус эзэлж байна (Зураг 2).

ЗУРАГ 2. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН НАСНЫ БҮЛЭГ, ХУВИАР, 2022 ОН




Хан-Уул дүүргийн иргэдийг ам бүлийн тоогоор авч үзэхэд ганц бие өрх 13055 буюу 5.5 хувь, 2 ам бүлтэй өрх 28139 буюу 11.8 хувь, 3 ам бүлтэй өрх 46127 буюу 19.3 хувь, 4 ам бүлтэй өрх 59645 буюу 25 хувь, 5 ам бүлтэй 21.4 хувь, 6 ам бүлтэй өрх 24971 буюу 10.5 хувь, 7 ам бүлтэй өрх 8011 буюу 3.4 хувь, 8 ба түүнээс дээш ам бүлтэй өрх 7434 буюу 3.1 хувийг тус тус эзэлж байна (Зураг 3).

ЗУРАГ 3. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ӨРХИЙН ТОО, 2023 ОН




Хан-Уул дүүргийн иргэдийн амьдарч буй байршлаар нь ангилж үзвэл 47.2 хувь буюу 112652 байшин хороолол, 6.2 хувь буюу 14723 гэр хороолол, 46.6 хувь буюу 111136 холимог хороодод амьдарч байна (Зураг 4).

ЗУРАГ 4. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН БАЙРШИЛ, ХОРООГООР, 2023 ОН



Хан-Уул дүүргийн хэмжээнд 2023 оны байдлаар 8.6 хувь нь гэрт, 19.6 хувь сууцны тусдаа байшин, 2.0 хувь бие даасан тохилог сууц, 68.2 хувь орон сууцны байшин, 1.1 хувь нийтийн байр, 0.6 хувь бусад сууц тус тус эзэлж байна (Зураг 5).

ЗУРАГ 5. АМЬДАРЧ БУЙ ОРЧНЫ СУУЦНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХУВИАР, 2023 ОН




Судалгаанд оролцсон иргэдийн боловсролын байдлаар авч үзвэл боловсролгүй иргэд 0.4 хувь, бага боловсролтой иргэд 1.1 хувь, суурь боловсролтой 2.9 хувь, бүрэн дунд боловсролтой 28.7 хувь, техникийн болон мэргэжлийн боловсролтой 10.1 хувь, дипломын болон бакалаврын 51.8 хувь, магистр/доктор 4.9 хувь, мэдэхгүй/санахгүй байна гэж хариулсан 0.1 хувийг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 3. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2023 ОН

Боловсролын түвшин	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	100.0	100.0
Боловсролгүй	41.7	58.3
Бага	50.9	49.1
Суурь	52.4	47.6
Бүрэн дунд	48.4	51.6
Техникийн болон мэргэжлийн	47.2	52.8
Дипломын болон бакалаврын дээд	39.8	60.2
Магистр/Доктор	45.3	54.7
Мэдэхгүй/санахгүй байна	70.4	29.6

Хан-Уул дүүргийн иргэдийн 18 ба түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдлыг гэрлэсэн / батлуулсан, батлуулаагүй/, огт гэрлээгүй, тусгаарласан, цуцалсан, бэлэвсэн гэсэн 6 бүлгээр авч үзсэн. 18 ба түүнээс дээш насны хүн амын 75.8 хувь нь гэрлэсэн, 17.1 хувь нь огт гэрлээгүй, 7.0 хувийг тусгаарласан, цуцалсан, бэлэвсэн тус тус эзэлж байна (Зураг 6).


ЗУРАГ 6. 18 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХУВИАР, 2023 ОН



2.3 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Судалгаанд хамрагдсан иргэдийн 62.7 хувь нь хөдөлмөр эрхэлдэг, 37.3 хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй байна. Хөдөлмөр эрхэлж буй иргэдийн 1.9 хувь ажил олгогч, 21.5 хувь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 39.2 хувь цалин хөлстэй ажиллагч тус тус эзэлж байна.

ЗУРАГ 7. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХУВЬ, 2023 ОН



Хөдөлмөр эрхлээгүй шалтгаантай байгаа иргэдийн 16.4 хувь нь сургуульд сурдаг, 42.4 хувь нь тэтгэвэрт, 3.6 хувь хөдөлмөр эрхлэх чадваргүй, 28.0 гэрийн ажилтай хүүхдээ хардаг, 9.5 хувь нь бусад шалтгаантай байна.

ХҮСНЭГТ 4. АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ҮНДСЭН ШАЛТГААН, ТӨРЛӨӨР, ХУВИАР, 2023 ОН


Ажил эрхлээгүй үндсэн шалтгаан	Эзлэх хувь
Сургуульд сурдаг	16.4
Тэтгэвэрт	42.4
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	3.6
Гэрийн ажилтай	28.0
Бусад /бичих/	9.5

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

3.1 БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ


Судалгаанд хамрагдсан иргэдийн Хан-Уул дүүрэгт амьдарч буй хугацааны байдлыг авч үзэхэд 2.6 хувь нь 6 сараас доош хугацаанд, 7.8 хувь нь 6 сараас 1 жил, 18.5 хувь нь 1.1-3 жил, 71.1 хувь нь 3-аас дээш жилээр тус тус амьдарч байна.

ЗУРАГ 8. ХАН-УУЛ ДҮҮРЭГТ АМЬДАРЧ БУЙ ХУГАЦАА, ХУВИАР, 2023 ОН



Хан-Уул дүүрэгт сүүлийн 3 жилд хэрэгжсэн томоохон бүтээн байгуулалт, тохижилтын ажлын талаар 6 сараас 1 жил хүртэл хугацаанд амьдарч буй иргэд, 1.1 буюу түүнээс дээш жил амьдарч буй иргэдээс асуухад: иргэдийн 16.9 хувь нь сургууль, 18.4 хувь нь цэцэрлэг, 20.2 хувь нь ахмадын эко сувилал, 17.5 хувь нь нүхэн гарц, 22.5 хувь нь туул голын дундын дугуйн зам, 4.5 хувь нь бусад ажил гэж хариулсан байна.


ЗУРАГ 9. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СҮҮЛИЙН 3 ЖИЛД ХЭРЭГЖСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛУУДЫГ НЭРЛЭСЭН БАЙДАЛ, ХУВИАР, 2023 ОН



Эндээс харахад дүүргээс явуулж байгаа томоохон бүтээн байгуулалтын ажлын талаар дүүргийн иргэд маань тодорхой мэдээлэлтэй байгааг илтгэн хариулж байна.

Таны амьдарч буй орчинд хүүхдийн тоглоомын талбай байдаг уу? гэсэн асуултад дүүргийн иргэдийн 70.6 хувь нь ойр орчимд тоглоомын талбай байдаг гэж хариулсан ба 63.3 хувь нь хангалттай, маш хангалттай гэж үнэлгээ өгсөн байна.

ЗУРАГ 10. АМЬДАРЧ БУЙ ОРЧИНД ТОГЛООМЫН ТАЛБАЙ БАЙДАГ ЭСЭХ, ХУВИАР, 2023 ОН




Амьдарч буй орчны хаана нь хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламжийн нэмэгдүүлмээр байна? гэсэн асуултад ихэвчлэн гэрийн ойр орчим, хотхондоо гэж нийт хүн амын 93.5 хувь нь, 1.5 хувь нь сургууль, цэцэрлэг, явган зам дагуу ойр орчим, 5 хувь нь энэ талаар сайн мэдэхгүй байна гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл иргэд өөрийн амьдарч буй ойр орчинд хүүхдийн ногоон байгууламж, тоглоомын талбайг нэмэгдүүлэх хүсэлтэй байгааг илэрхийлжээ.

ЗУРАГ 11. ТОГЛООМЫН ТАЛБАЙ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БАЙРШИЛ, ХУВИАР




Амьдарч буй орчны хаана нь гэрэлтүүлэг нэмэгдүүлмээр байна гэсэн асуултад нийт хүн амын 96.0 хувь нь гудамж, байрны ойр орчимд, 1.0 хувь нь авто зам, явган зам дагуу ойр орчим, 3.0 хувь нь энэ талаар сайн мэдэхгүй байна гэсэн хариултуудыг ирүүлсэн.

ЗУРАГ 12. ГЭРЭЛТҮҮЛЭГ НЭМЭХ БАЙРШИЛ, ХУВИАР



Таны амьдарч буй орчинд гэрэлтүүлэг байдаг уу? гэсэн асуултыг авч үзвэл дүүргийн иргэдийн 89.6 хувь нь ойр орчимд гэрэлтүүлэг байдаг (Зураг 14) гэсэн ба 68.3 хувь нь хангалттай түвшинд байгаа гэж хариулжээ. (Зураг 13)

ЗУРАГ 13. АМЬДАРЧ БУЙ ОРЧИНД ГЭРЭЛТҮҮЛЭГ БАЙДАГ ЭСЭХ, ХУВИАР




ЗУРАГ 14. ГЭРЭЛТҮҮЛГИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ, ХУВИАР




Дүүргийн хэмжээнд иргэдийн чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх, амрах талбайг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаар иргэдийн 43.0 хувь нь мэднэ (Зураг 16) гэж хариулсны 49.6 хувь нь хүртээмжтэй (Зураг 16) гэж үзсэн байна. Үлдсэн 40.0 хувь нь иргэдийн чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх, амрах талбайг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаар мэдэхгүй, үгүй гэж хариулсан нь цаашид чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх талбайг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

ЗУРАГ 15. ИРГЭДИЙН АЯ ТУХТАЙ АМРАХ ТАЛБАЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛЫН ТАЛААР МЭДДЭГ ЭСЭХ ХУВИАР



ЗУРАГ 16. ИРГЭДИЙН АЯ ТУХТАЙ АМРАХ ТАЛБАЙГ НЭМЭГДҮҮЛСЭН АЖЛУУД ХҮРТЭЭМЖТЭЙ ЭСЭХ, ХУВИАР




ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРҮҮЛ МЭНД

4.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

Судалгаанд хамрагдсан Хан-Уул дүүргийн иргэдийн 58.3 хувь нь эрүүл мэндийн нэгдсэн төвөөр үйлчлүүлж байсан бол 41.7 хувь нь үйлчилгээ авч байгаагүй байна. Үйлчлүүлж байсан иргэдийн 40.6 хувь эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэхэд огт болон бараг хүндрэлгүй гэж хариулжээ (Зураг 17).

ЗУРАГ 17. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨР ҮЙЛЧИЛГЭЭ АВАХАД ХЭР ЗЭРЭГ ХҮНДРЭЛ УЧИРСАН ЭСЭХ, ХУВИАР



Дүүргийн Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж байсан иргэдээс тухайн төвийн үйлчилгээ харилцааг хандлага, мэдлэг туршлага, үйлчилгээний чанар, байрны тохижилт, дотоод орчин, эмнэлгийн үйлчилгээний хүлээлт зэрэгт үнэлгээ өгөх байдлаар судалгааг авсан. Үйлчилгээ тус бүрийг 1-9 оноогоор үнэлсэн. Хамгийн муу 1, хамгийн сайн үнэлгээг 9 гэж тооцсон.

ХҮСНЭГТ 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ


Оноо (Хамгийн муу -1, хамгийн сайн үнэлгээ -9)	Эрүүл мэндийн төвийн дотоод орчны ая тух, цэвэрхэн эсэхэд өгсөн үнэлгээний эзлэх хувь	Эмч, эмнэлгийн ажилчдын харилцаа, ёс зүйд өгсөн үнэлгээний эзлэх хувь	Эмнэлгийн үйлчилгээний хүлээлт, ачаалалд өгсөн үнэлгээний эзлэх хувь	Эмч, эмнэлгийн мэргэжилтний үйлчлүүлэгчийг сонсох, зөвлөгөө өгөх чадварт өгсөн үнэлгээний эзлэх хувь
1	1.4	1.7	5.2	1.5
2	0.7	0.9	2.7	1.0
3	2.2	2.9	4.5	2.5
4	3.2	3.6	5.7	4.1
5	30.0	29.7	28.1	29.1
6	17.4	18.2	17.4	18.2
7	20.2	20.5	16.9	20.9
8	12.9	11.7	9.7	11.3
9	12.0	10.8	9.8	11.4
Дүн	100.0	100.0	100.0	100.0

Дүүргийн эрүүл мэндийн төвийн дотоод орчин хэр тохилог ая тухтай, цэвэрхэн байдалд өгсөн үнэлгээнд өгсөн хувийг авч үзэхэд, 10.6 хувь нь 1-2 оноо, 5.4 хувь нь 3-4 оноо, 30 хувь нь 5 оноо, 37.6 хувь нь 6-7 оноо, 24.9 хувь нь 8-9 оноог өгчээ. Мөн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн ажилчдын харилцаа, ёс зүйн байдалд өгсөн үнэлгээг авч үзэхэд, 2.6 хувь нь 1-2 оноо, 6.5 хувь нь 3-4 оноо, 29.7 хувь нь 5 оноо, 38.7 хувь нь 6-7 оноо, 22.5 хувь нь 8-9 оноо өгсөн байна.

Дүүргийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлсэн иргэд эмнэлгийн үйлчилгээний хүлээлт, ачаалалд өгсөн үнэлгээг авч үзэхэд, 7.9 хувь нь 1-2 оноо, 10.2 хувь нь 3-4 оноо, 28.1 хувь нь 5 оноо, 34.3 хувь нь 6-7 оноо, 19.5 хувь нь 8-9 оноог өгсөн бол эмч, эмнэлгийн мэргэжилтний үйлчлүүлэгчийг сонсох, зөвлөгөө өгөх чадварт 2.5 хувь нь 1-2 оноо, 6.6 хувь нь 3-4 оноо, 29.1 хувь нь 5 оноо, 39.1 хувь нь 6-7 оноо, 22.7 хувь нь 8-9 оноо тус тус өгсөн байна.

Хан-Уул дүүргийн иргэдийн 46.7 хувь нь эрүүл мэндийн нэгдсэн эмнэлгээр үйлчлүүлж байсан бол 53.3 хувь нь үйлчилгээ авч байгаагүй гэж хариулжээ. Үйлчлүүлж байсан иргэдийн 39.1 хувь эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэхэд хүндрэлгүй гэж хариулсан байна.

ЗУРАГ 18. НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХҮНДРЭЛТЭЙ ЭСЭХ, ХУВИАР



Дээрх үнэлгээг нэгдсэн эмнэлгээр үйлчлүүлж байсан иргэдээс авсан. Үйлчилгээ тус бүрийг 1-9 оноогоор үнэлж, хамгийн муу -1, хамгийн сайн үнэлгээг -9 гэж тооцсон.

ХҮСНЭГТ 6. НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ


Оноо (Хамгийн муу -1, хамгийн сайн үнэлгээ -9)	Дотоод орчин хэр тохилог ая тухтай, цэвэрхэн байдалд өгсөн үнэлгээнд эзлэх хувь	Эмч, эмнэлгийн ажилчдын харилцаа, ёс зүйд өгсөн үнэлгээний эзлэх хувь	Эмнэлгийн үйлчилгээний хүлээлт, ачаалалд өгсөн үнэлгээний эзлэх хувь	Эмч, эмнэлгийн мэргэжилтний үйлчлүүлэгчийг сонсох, зөвлөгөө өгөх чадварт өгсөн үнэлгээний эзлэх хувь
1	1.3	2.2	5.5	1.6
2	1.1	0.6	2.7	0.9
3	2.1	3.0	5.4	2.8
4	3.0	4.1	6.6	3.9
5	35.0	34.1	31.1	34.0
6	14.3	14.5	12.6	15.0
7	21.8	20.9	17.7	20.2
8	9.8	10.1	8.6	10.4
9	11.7	10.4	9.7	11.3
Дүн	100.0	100.0	100.0	100.0

Нэгдсэн эмнэлгийн дотоод орчин хэр тохилог ая тухтай, цэвэрхэн байдалд өгсөн үнэлгээнд өгсөн хувийг авч үзэхэд, 2.4 хувь нь 1-2 оноо, 5.1 хувь нь 3-4 оноо, 35 хувь нь 5 оноо, 36.1 хувь нь 6-7 оноо, 21.5 хувь нь 8-9 оноог өгчээ. Мөн нэгдсэн эмнэлгийн эмч, эмнэлгийн ажилчдын харилцаа, ёс зүйн байдалд өгсөн үнэлгээний хувийг авч үзвэл, 2.8 хувь нь 1-2 оноо, 7.1 хувь нь 3-4 оноо, 34.1 хувь нь 5 оноо, 35.4 хувь нь 6-7 оноо, 20.5 хувь нь 8-9 оноог тус тус өгсөн байна.


Нэгдсэн эмнэлгээр үйлчлүүлж байгаа иргэд эмнэлгийн үйлчилгээний хүлээлт ачаалалд өгсөн үнэлгээг авч үзвэл, 8.2 хувь нь 1-2 оноо, 12 хувь нь 3-4 оноо, 31.1 хувь нь 5 оноо, 30.3 хувь нь 6-7 оноо, 18.3 хувь нь 8-9 оноог өгсөн бол эмч, эмнэлгийн мэргэжилтний үйлчлүүлэгчийг сонсох, зөвлөгөө өгөх чадварт 2.5 хувь нь 1-2 оноо, 5.9 хувь нь 3-4 оноо 34.0 хувь нь 5 оноо, 35.2 хувь нь 6-7 оноо, 21.7 хувь нь 8-9 оноог тус тус өгсөн байна.

Хан-Уул дүүргийн иргэдийн 72.7 хувь нь өрхийн эмнэлгээр үйлчлүүлж байсан бол 27.3 хувь нь үйлчилгээ авч байгаагүй байна (Зураг 19). Үйлчлүүлж байсан иргэдийн 39.1 хувь нь эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэхэд бараг болон огт хүндрэлгүй гэж үзсэн байна (Зураг 20).

ЗУРАГ 19. ӨРХИЙН ЭМНЭЛГЭЭР ҮЙЛЧЛҮҮЛДЭГ ЭСЭХ, ХУВИАР




ЗУРАГ 20. ӨРХИЙН ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХҮНДРЭЛТЭЙ ЭСЭХ, ХУВИАР




Дараах зургаас харахад судалгаанд оролцогчдын 74.3 хувь нь эрүүл мэндийн үйлчилгээг авч байсан байна (Зураг 21). Дүүргийн иргэдийн 63.2 хувь нь эрүүл мэндийг үйлчилгээг цахимаар цаг авч үзүүлдэг байна (Зураг 22).

ЗУРАГ 21. ЭРҮҮЛ МЭНДИЙГ ҮЙЛЧИЛГЭЭГ АВСАН ЭСЭХ, ХУВИАР




ЗУРАГ 22. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМААР ЦАГ ҮЗҮҮЛЖ ЧАДДАГ ЭСЭХ, ХУВИАР




Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд дүүргийн иргэдийн 53.9 хувь нь хамрагджээ (Зураг 23). Харин эдгээр үзлэг, оношилгоо, шинжилгээний талаарх мэдээллийг иргэдийн 69.7 хувь нь хорооноос болон цахим орчноос авдаг байна (Зураг 24).

ЗУРАГ 23. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ЭРТ ИЛРҮҮЛЭХ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ
ОНОШИЛГООНД ХАМРАГДСАН ЭСЭХ, ХУВИАР



ЗУРАГ 24. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ
ИЛРҮҮЛЭХ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ
ОНОШИЛГООНЫ МЭДЭЭЛЭЛ АВСАН
ЭХ ҮҮСВЭР, ХУВИАР




ТАВДУГААР БҮЛЭГ. АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

5.1 АМЬДАРЧ БУЙ ОРЧНЫ ТАЛААРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ


Хан-Уул дүүргийн хэмжээнд 2023 оны байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа сууц өмчлөгчдийн холбооны (СӨХ) 30.1 хувь нь тогтмол, 29.1 хувь нь заримдаа, 20.0 хувь нь ихэнхдээ, 11.5 хувь хааяа үйл ажиллагаа явуулдаг бол 9.3 хувь нь бараг үйл ажиллагаа явуулдаггүй байна.

ЗУРАГ 25. АМЬДАРЧ БУЙ ГАЗАР СӨХ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ЭСЭХ, ХУВИАР




Хан-Уул дүүргийн хэмжээнд 2023 оны байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа СӨХ-ийн 30.1 хувь нь тогтмол, 29.1 хувь нь заримдаа, 20.0 хувь нь ихэнхдээ, 11.5 хувь хааяа үйл ажиллагаа явуулдаг бол 9.3 хувь нь бараг үйл ажиллагаа явуулдаггүй байна.

ЗУРАГ 26. СӨХ -ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ТАЛААР ИРГЭДЭЭС САНАЛ АВДАГ БАЙДАЛ, ХУВИАР




Дүүргийн хүн амын 52.6 хувь нь аюулгүй орчинд амьдарч чадаж байгаа гэж хариулжээ. Харин 25.7 хувь нь аюулгүй орчинд амьдардаггүй, үлдсэн 21.7 хувь нь мэдэхгүй гэсэн байна.

ЗУРАГ 27. АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДАРЧ ЧАДАЖ БУЙ ЭСЭХ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР




Дүүргийн хэмжээнд хамгийн өндөр буюу 40.3 хувь нь хэрэглээний усны чанар дунд зэрэг гэж үзсэн байна (Зураг 28). Хан-Уул дүүргийн иргэдийн дийлэнх буюу 76.8 хувь нь амьдарч буй ойр орчимд дуу чимээ ихтэй гэж үзжээ (Зураг 29).

ЗУРАГ 28. ХЭРЭГЛЭЭНИЙ УСНЫ ЧАНАР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР




ЗУРАГ 29. АМЬДАРЧ БУЙ ГАЗРЫН ОЙР ОРЧИМ ДУУ ЧИМЭЭТЭЙ ЭСЭХ ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР



Дүүргийн иргэдийн амьдардаг газрын ойролцоо цэцэрлэг сургууль байдаг гэж 64.3 хувь нь хариулжээ. Судалгааны үр дүнг задлан харвал цэцэрлэг, сургуулийн хүртээмжид 40.1 хувь нь дунд зэрэг буюу цэцэрлэгийн сургуулийн хүртээмж тааруу гэж үзсэн байна.

ЗУРАГ 30. АМЬДАРДАГ ГАЗРЫН ОЙРОЛЦООХ ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛИЙН ХҮРТЭЭМЖ, ХУВИАР



ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХОГ ХАЯГДАЛ


6.1 ХОГ ХАЯГДЛЫН ТАЛААРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

Хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор хийгдсэн ажлын үр дүнд дүүргийн хог тээврийн байгууллагын чанар сайжирсан гэж судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 48.4 хувь нь үзэж байна (Хүснэгт 7). Дүүргийн иргэдийн 81.4 хувь нь амьдардаг газрын ойр орчимд хоггүй цэвэр байдлыг дунд зэрэг болон сайн гэж үнэлжээ (Зураг 31).

ХҮСНЭГТ 7. ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙДАЛ, ХУВИАР

Хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын ажлын үр дүнгийн нөлөөлөл	Судалгаанд оролцогчид	
	Тоо	Эзлэх хувь
Бүгд	238 511	100.0
Хог тээврийн байгууллагын үйлчилгээний чанар сайжирсан	115 534	48.4
Орчны ил задгай хог хаягдал багассан	65 413	27.4
Сайн мэдэхгүй байна	45 590	19.1
Чанар сайжраагүй байна	11 122	4.7
Бусад	852	0.4


ЗУРАГ 31. АМЬДАРЧ БУЙ ГАЗРЫН ОЙР ОРЧИМ ЦЭВЭР, ХУГАЦААНДАА ХОГОО АЧДАГ БАЙДАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР




2023 онд дүүргийн иргэдийн 37.9 хувь нь өөрийн амьдардаг газрын ойр орчимд зам талбай эвдрэлтэй гэж хариулсан бөгөөд үүнээс эвдрэл засварлах ажлыг 41.9 хувь нь дундаж гэж үзсэн байна (Зураг 32).

Орчны бохирдлын чиглэлээр буюу хог ангилан ялгалтын сургалт, мэдээ мэдээлэл, бүх нийтийн цэвэрлэгээний зар, санал гомдол гэх зэрэг аль ч хэлбэрээр хороо дүүрэгтэй хамтран ажиллаж хүссэн мэдээллээ авч, санал хүсэлтээ авч чаддаг эсэхэд 38.7 хувь нь мэдээллээ авч чаддаг, 39.4 хувь нь зарим асуудлаар л чаддаг гэж хариулсан байна (Зураг 33).

ЗУРАГ 32. АМЬДАРЧ БУЙ ГАЗРЫН ОЙР ОРЧМЫН ЗАМ ТАЛБАЙ ЗАСВАРЛАХ АЖИЛД ӨГЧ БУЙ ҮНЭЛГЭЭ, ХУВИАР



ЗУРАГ 33. ДҮҮРЭГ, ХОРООТОЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ ХҮССЭН МЭДЭЭЛЛЭЭ АВЧ, САНАЛ ХҮСЭЛТЭЭ АВЧ ЧАДДАГ ЭСЭХ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР




ДОЛООДУГААР БҮЛЭГ. ХОРООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ


7.1 ХОРООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

Хан-Уул дүүргийн иргэдийн 78.7 хувь нь хороогоор үйлчлүүлдэг бөгөөд үйлчлүүлсэн хүмүүсийн 60.8 хувь нь төрийн үйлчилгээг нэг дор, хорооноос авч чаддаг гэж үзжээ.

ЗУРАГ 34. ХОРООГООР ҮЙЛЧЛҮҮЛЖ БАЙСАН ЭСЭХ, ХУВИАР



ЗУРАГ 35. ХОРООНООС ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ НЭГ ДОР АВЧ ЧАДАЖ БАЙГАА ЭСЭХ, ХУВИАР



Үйлчилгээ тус бүрийг 1-9 оноогоор үнэлсэн бөгөөд маш муу 1, маш сайн үнэлгээг 9 гэж тооцсон (Хүснэгт 8). Иргэд хорооны үйлчилгээг сайн, маш сайн гэж 71.9 хувь нь үнэлгээ өгсөн ба хорооны орчин нөхцөлийг нийт иргэдийн 67.8 хувь нь 7-9 оноо буюу дундаас дээш сайн гэсэн үнэлгээг өгчээ.


ХҮСНЭГТ 8. ХОРООДЫН АЛБАН ХААГЧДАД ӨГСӨН ҮНЭЛГЭЭНИЙ ЭЗЛЭХ ХУВЬ

Оноо (Хамгийн муу - 1, хамгийн сайн үнэлгээ -9)	Хороодын албан хаагчдын хандлага, харилцаанд өгсөн үнэлгээний эзлэх хувь	Хорооны үйлчлүүлж буй орчин нөхцөлд өгсөн үнэлгээний эзлэх хувь	Хорооны албан хаагчдын мэдлэг, туршлагад өгсөн үнэлгээний эзлэх хувь	Хорооны үйлчилгээний хурдан шуурхай байдалд өгсөн үнэлгээний эзлэх хувь	Хорооны зүгээс шийдвэрлэх байдалд өгсөн үнэлгээний эзлэх хувь
1	0.2	0.8	0.3	0.3	0.4
2	0.1	0.3	0.1	0.2	0.3
3	0.7	0.7	0.5	0.4	0.9
4	1.4	2	1.2	1.2	1.8
5	11.1	12.7	10.1	10.8	13.5
6	14.7	15.7	12.9	13.1	13.5
7	23.5	23.3	23.6	23.1	22.9
8	23.3	21.7	24.6	24.7	23.5
9	25.1	22.8	26.6	26.2	23.1
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0


Хорооны албан хаагчдын мэдлэг туршлагад өгсөн үнэлгээнд нийт иргэдийн 74.8 хувь нь, хорооны үйлчилгээний шуурхай байдалд дүүргийн иргэдийн 74.0 хувь нь 7-9 оноо буюу дундаас дээш сайн гэж хариулжээ. Иргэдийн хүсэж буй үйлчилгээг шийдэж буй байдалд 69.5 хувь нь сайн, маш сайн гэсэн үнэлгээг өгчээ.

Хорооноос ихэнхдээ ямар үйлчилгээ авахын тулд үйлчлүүлдэг вэ гэсэн асуултад иргэдийн 63.0 хувь нь лавлагаа болон тодорхойлолт авахаар үйлчлүүлдэг гэж хариулсан байхад 24.5 хувь нь бүртгэлтэй холбоотойгоор үйлчлүүлдэг байна (Зураг 36). Дүүргийн иргэдийн 55.0 хувь нь үйлчилгээ авах явцад албан хаагч ажлаа мэддэггүй гэсэн асуудалтай тулгардаг байна (Зураг 37).

ЗУРАГ 36. ХОРООГООР ҮЙЛЧЛҮҮЛДЭГ ШАЛТГААН, ХУВИАР




ЗУРАГ 37. ХОРООНООС ҮЙЛЧИЛГЭЭ АВАХАД ТУЛГАРСАН ХҮНДРЭЛ, ХУВИАР




Дүүргийн иргэдийн 66.9 хувь нь төрийн үйлчилгээг цахимаар авдаг байна (Зураг 38). Дүүргийн амралтын газар, жуулчны бааз, зочид буудлуудын үйл ажиллагаа, үйлчилгээний соёлд иргэдийн 86.5 хувь нь дунд зэрэг болон сайн гэсэн хариултуудыг өгчээ (Зураг 39).

ЗУРАГ 38. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМААР АВЧ ЧАДАЖ БАЙГАА БАЙДАЛ, ХУВИАР



ЗУРАГ 39. ДҮҮРГИЙН АМРАЛТЫН ГАЗАР, ЖУУЛЧНЫ БААЗ, ЗОЧИД БУУДЛУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ, ХУВИАР




Иргэдийн зүгээс үйлчилгээний соёлыг сайжруулах шаардлагатай ажлын талаарх саналд 54.3 хувь нь албан хаагчдын харилцаа, хандлагад анхаарах, 32.1 хувь нь албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх, 13.6 хувь нь үйлчилгээний стандарт мөрдөх шаардлагатай гэж саналаа өгсөн байна (Зураг 40).

ЗУРАГ 40. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ АЖЛЫН САНАЛ, ХУВИАР



Дүүргийн нэг цэгийн үйлчилгээгээр үйлчлүүлж байсан эсэхэд иргэдийн 56.8 хувь нь үйлчлүүлж үзээгүй гэж хариулсан (Зураг 41). Харин нэг цэгийн үйлчилгээгээр үйлчлүүлж байсан иргэдийн тухайн үйлчилгээ үзүүлэгчдийн харилцаа, хандлагад өгсөн үнэлгээг харахад 5-8 оноо гэж хариулсан нь дийлэнх буюу 81.1 хувийг эзэлж байна. (Хүснэгт 9).

ЗУРАГ 41. ДҮҮРГИЙН НЭГ ЦЭГЭЭР ҮЙЛЧЛҮҮЛЖ БАЙСАН ЭСЭХ, ХУВИАР




ХҮСНЭГТ 9. НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ӨГСӨН ҮНЭЛГЭЭНИЙ ЭЗЛЭХ ХУВЬ

Оноо (Хамгийн муу - 1, хамгийн сайн үнэлгээ -9)	Нэг цэгийн үйлчилгээний албан хаагчдын хандлага, харилцаанд өгсөн үнэлгээний эзлэх хувь	Нэг цэгийн үйлчилгээний албан хаагчдын мэдлэг, туршлагад өгсөн үнэлгээний эзлэх хувь	Нэг цэгийн үйлчилгээний чанарт өгсөн үнэлгээний эзлэх хувь	Нэг цэгийн үйлчилгээний байрны тохижилт, орчинд өгсөн үнэлгээний эзлэх хувь	Нэг цэгийн үйлчилгээний нууцлал, аюулгүй байдалд өгсөн үнэлгээний эзлэх хувь
1	1.0	0.5	0.7	0.6	1.0
2	0.6	0.5	0.5	0.5	0.5
3	1.2	1.4	1.5	1.4	1.3
4	2.2	1.9	1.4	1.8	1.6
5	20.9	18.3	19.7	17.4	20.3
6	18.3	16.8	17.7	14.6	15.0
7	24.5	26.6	25.4	24.7	25.1
8	17.4	18.2	18.0	18.4	18.0
9	14	15.8	15.2	20.6	17.2
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0

Дүүргийн нэг цэгээр үйлчлүүлж байсан иргэдийн тухайн үйлчилгээ үзүүлэгчид болох албан хаагчдын мэдлэг, туршлагад өгсөн үнэлгээг авч үзэхэд 4.3 хувь нь 1-4 оноо, 79.9 хувь нь 5-8 оноо, 15.8 хувь нь 9 оноо гэсэн хариулт өгчээ. Дүүргийн иргэдийн дийлэнх буюу 96 хувь нь нэг цэгийн үйлчилгээний чанарыг 5-9 оноо гэсэн хариулт өгчээ. Нэг цэгийн үйлчилгээний байрны тохижилт, орчинд өгсөн үнэлгээг харахад 4.3 хувь нь 1-4 оноо, 95.7 хувь нь 5-9 оноо гэсэн хариулсан байна. Дүүргийн иргэдийн 95.6 хувь нь нэг цэгийн үйлчилгээний нууцлал, аюулгүй байдалд өгсөн дунд зэрэг болон сайн, маш сайн гэсэн үнэлгээг өгчээ. (Хүснэгт 9)

ХУРДАН төрийн үйлчилгээний цэгээр иргэдийн 65.6 хувь нь үйлчлүүлж үзээгүй гэж хариулсан бол 34.4 хувь нь үйлчлүүлсэн гэж хариулжээ (Зураг 42). Дүүргээс явуулж буй бодлого шийдвэрийн талаар иргэдийн 57.6 хувь нь интернэтээс мэдээллээ авдаг гэж хариулсан байна (Зураг 43).

ЗУРАГ 42. ХУРДАН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГЭЭР ҮЙЛЧЛҮҮЛЖ БАЙСАН ЭСЭХ, ХУВИАР




ЗУРАГ 43. ДҮҮРГЭЭС ЯВУУЛЖ БУЙ БОДЛОГО ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭН АВДАГ ЭХ ҮҮСВЭР, ХУВИАР



Дүүргээс хэрэгжүүлж буй төрийн үйлчилгээний талаар 49.4 хувь нь сургууль, цэцэрлэг нэмэгдүүлэх, 37.9 хувь нь ногоон байгууламж дахин нэмэгдүүлэх, 12.7 хувь нь иргэдээс санал авдаг байх гэсэн хариултуудыг өгсөн байна (Зураг 44).

ЗУРАГ 44. ДҮҮРГЭЭС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ САНАЛ, ХУВИАР



ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хан-Уул дүүргийн Засаг Даргын Тамгын газрын зүгээс Статистикийн хэлтэстэй хамтран дүүргээс явуулж буй бодлогын хэрэгжилтэд иргэдийн хүлээлт, сэтгэл ханамжийн талаар судлахаар Хан-Уул дүүргийн 238511 хүн амыг төлүүлэх чадвартай түүврээр 4784 хүн амыг хамруулсан судалгааг хийлээ. Иргэдийн санал бодлыг дэд хэсэгт нарийвчлан танилцуулсан болно.

Хан-Уул дүүргийн хүн ам зүйн шинж байдлыг авч үзэхэд судалгаан хамрагдсан дүүрэгт амьдарч буй 18-аас дээш насны иргэнээс 43.8 хувь нь эрэгтэйчүүд, 56.8 хувь эмэгтэйчүүд бөгөөд хороодод хүйсийн харьцаа харилцан адилгүй байна. Насны бүлгээр авч үзэхэд 28-47 насныхан 51.8 хувийг эзэлж байгаа бөгөөд 3-5 ам бүлтэй өрх дийлэнх хувийг эзэлж байна. Судалгаанд оролцогчдын 75.8 хувь нь гэрлэсэн бөгөөд 51.8 хувь нь дээд бакалаврын боловсролтой байна. Харин дүүргийн иргэдийн 62.7 хувь буюу 149459 хөдөлмөр эрхэлдэг байхад 37.3 хувь буюу 89052 хөдөлмөр эрхэлдэггүй байна. Хөдөлмөр эрхэлдэггүй шалтгааныг авч үзвэл оюутан болон тэтгэврийн насныхан дийлэнх хувийг эзэлж байна. Судалгаан оролцсон иргэдийн 68.2 хувь орон сууцны байшинд амьдардаг болсон байна.

Бүтээн байгуулалтын талаарх хэсэгт Хан-Уул дүүрэгт оршин суугчдын 71.1 хувь нь дүүрэгтээ 3-аас дээш жил амьдарсан бөгөөд иргэдийн зүгээс дүүргийн сүүлийн 3 жилд сургууль, цэцэрлэг, ахмадын эко сувилал, нүхэн гарц, туул голын дундын дугуйн зам гэх зэрэг бүтээн байгуулалтууд хийгдсэн талаар нэрлэжээ. Иргэдийн амьдарч буй ойр орчимд хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, гэрэлтүүлэг байдаг гэж хариулсан боловч цаашид ихээр нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзжээ.

Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой хэсэгт эрүүл мэндийн төвөөр иргэдийн 58.3 хувь, эрүүл мэндийн нэгдсэн эмнэлгээр иргэдийн 46.7 хувь, өрхийн эмнэлгээр иргэдийн 72.7 хувь нь үйлчлүүлж байсан гэж хариулжээ. Эрүүл мэндийн төв болон эрүүл мэндийн нэгдсэн эмнэлгээс үйлчилгээ авахад хүндрэл учруулдаг эсэхэд дунд зэргийн хүндрэлтэй гэж хариулсан байхад өрхийн эмнэлгийн тухайд бараг хүндрэлгүй болон дунд зэргийн хүндрэлтэй гэж 67.2 хувь нь хариулжээ. Дүүргийн эрүүл мэндийн төвийн дотоод орчны ая тух, цэвэрхэн байдал, эмч эмнэлгийн мэргэжилтний харилцаа, ёс зүй, эмнэлгийн үйлчилгээний хяналт, ачаалал, эмч эмнэлгийн мэргэжилтний үйлчлүүлэгчийг сонсох, зөвлөгөө өгөх чадварт өгсөн үнэлгээ 60.0 хувиас дээш буюу 5-7 оноог өгчээ. Нэгдсэн эмнэлгийн тухайд иргэдийн 70.0 хувиас дээш буюу 5-7 оноог өгсөн байна. Иргэдийн 53.9 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдсан бөгөөд уг мэдээллийг хороо, цахим орчин, өрхийн эмнэлгээс тус тус авсан гэж хариулжээ.

Амьдарч буй орчинтой холбоотой хэсэгт иргэдийн амьдарч буй газарт үйл ажиллагаа явуулж байгаа СӨХ нь үйл ажиллагаагаа сайжруулах талаар тодорхой хэмжээнд иргэдээс санал авдаг байна. Дүүргийн иргэдийн 52.6 хувь нь аюулгүй орчинд амьдарч чадаж байгаа гэж үзсэн байгаа нь чамлалттай үзүүлэлт байна. Мөн хэрэглээний цэвэр усны чанарыг дунд зэрэг гэж 40.0 хувь нь үзсэн бөгөөд хороогоор задлан харвал 24-р хорооны иргэдээс хэрэглээний усны чанарт дийлэнх нь маш муу үнэлгээг өгчээ. Иргэдийн хувьд зэвтэй усны талаар хэд хэдэн хүсэлтийг өгсөн хэдий ч одоо болтол дорвитой шийдвэр гараагүй байгааг харуулж байна. Дүүргийн иргэдийн 76.8 хувь нь амьдарч буй орчинд дуу чимээ ихтэй байдаг гэж хариулт өгсөн байна. Цэцэрлэг, сургуулийн хүртээмж 40.1 хувь нь тааруу гэж үзэж буй нь яармаг, нисэхийн ойр орчим

орон сууцны барилга нэмэгдэж тэр хэрээр оршин суугчид нэмэгдсэн хэдий ч цэцэрлэг, сургууль харьцангуй хүртээмжгүй байгааг илтгэж байна.

Хог хаягдалтай холбоотой хэсэгт иргэдийн 75.8 хувь нь орчны ил задгай хог хаягдал багассан, хог тээврийн үйлчилгээний чанар сайжирсан гэж үзсэн байгаа нь дүүргээс хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор хийгдсэн ажил үр дүнтэйг байгааг харуулж байна. Иргэдийн 37.9 хувь нь зам талбай эвдрэл ихтэй гэж үзсэн бөгөөд засварлах ажлыг дүгнэхдээ 41.9 хувь нь боломжийн гэж үзжээ.

Хороо болон дүүргийн нэг цэгийн үйлчилгээтэй холбоотой хэсэгт дүүргийн иргэдийн 78.7 хувь нь хороогоор үйлчлүүлж байсан бөгөөд 60.0 хувиас дээш нь төрийн үйлчилгээг нэг дор хорооноос авч чаддаг мөн төрийн үйлчилгээг цахимаар авч чаддаг тухай дурджээ. Иргэд лавлагаа болон тодорхойлолт, бүртгэлтэй холбоотойгоор хорооноос үйлчилгээ авдаг байна. Хороодын албан хаагчдын хандлага, харилцаа, орчин нөхцөл, албан хаагчдын мэдлэг, туршлага, үйлчилгээний хурдан шуурхай байдал, хорооны зүгээс шийдвэрлэх байдалд үнэлгээ өгөхдөө 7-9 оноо буюу сайн үнэлгээг 70.0 хувиас дээш өгсөн байна. Иргэдийн зүгээс үйлчилгээний соёлыг сайжруулахад албан хаагчдын харилцаа, хандлагыг дээшлүүлэх, албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх, үйлчилгээний стандартыг мөрдөх гэсэн саналуудыг өгсөн байна. Дүүргийн нэг цэгээр үйлчлүүлж байсан иргэдээс албан хаагчдын харилцаа хандлага, мэдлэг, туршлага, үйлчилгээний чанар, байрны орчин нөхцөл, үйлчилгээний нууцлал, аюулгүй байдалд 75.0 хувиас дээш хувь нь 5-8 онооны үнэлгээ өгсөн.

ХУРДАН төрийн үйлчилгээний цэгээр дүүргийн иргэдийн 65.6 хувь нь үйлчлүүлж үзээгүй гэсэн хариулт өгсөн байгаа нь төрийн цахим болон нэг цэгийн үйлчилгээг иргэдэд сурталчлан таниулах ажлуудыг дүүргийн зүгээс хийх нь зүйтэй гэж үзэж байна. Хан-Уул дүүргээс явуулж буй бодлого шийдвэрийн талаар иргэдийн 56.7 хувь нь интернэтээс олж мэддэг байна. Дүүргээс хэрэгжүүлэх ёстой гэж үзэж буй иргэдийн хариултын хамгийн эхний 3-т **цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, иргэдээс тогтмол санал авдаг байх** гэсэн саналуудыг тодотгожээ.

ХАВСРАЛТ А

Төрөөс явуулж буй бодлогын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа-2023 он

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хаягийн хэсэг

№	Асуулт	Хариулт	Код	Алхам
1	Өрхийн дугаар			
1.1	Судалгаанд хамрагдаж буй хүний нэр			
1.2	Судалгаанд хамрагдсан хүний дугаар			
2	Баг, хорооны нэр			
3	Хаягийн хэсэг:			
4	Оршин суугаа бүртгэл:	Тухайн хаяганд амьдардаг мөн албан ёсны бүртгэлтэй	1	
		Тухайн хаяганд амьдардаг мөн албан ёсны бүртгэлгүй	2	
		Тухайн хаяганд амьдардаггүй мөн албан ёсны бүртгэлтэй	3	
		Тухайн хаяганд амьдардаггүй мөн албан ёсны бүртгэлгүй	4	

Хүн ам зүйн шинж байдал

5	Танай ам бүлийн тоо?			
6	Та хэдэн настай вэ?	Бүтэн насаар бичнэ		
7	Таны хүйс	Эрэгтэй	1	
		Эмэгтэй	2	
8	Таны эзэмшсэн боловсролын дээд түвшин юу вэ?	Боловсролгүй	1	
		Бага	2	
		Суурь	3	
		Бүрэн дунд	4	
		Техникийн болон мэргэжлийн	5	
		Дипломын болон бакалаврын дээд	6	
		Магистр/Доктор	7	
		Мэдэхгүй/санахгүй байна	8	
9	Таны гэрлэлтийн байдал	Огт гэрлээгүй	1	
		Гэрлэсэн: Батлуулсан	2	
		Батлуулаагүй	3	
		Тусгаарласан	4	
		Цуцалсан	5	
		Бэлэвсэн	6	
10	Та ажил эрхэлдэг үү?	Тийм	1	
		Үгүй	2	12
11	Ажил эрхлэлтийн байдал	Цалин хөлстэй ажиллагч:		
		Төсвийн болон төрийн оролцоот байгуул	1	
		Олон нийтийн байгууллага/ТББ	2	
		Хувийн компани/ААН	3	
		Ажил олгогч:		
		ААНБ-ын	4	
		Хувиараа эрхлэх аж ахуй, нөхөрлөл, хор	5	
		Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	6	13

12	Ажил эрхэлдэггүй шалтгаан	Сургуульд сурдаг	1		
		Тэтгэвэрт	2		
		Хөдөлмөр эрхлэх чадваргүй	3		
		Гэрийн ажилтай	4		
		Бусад /бичих/	5		
13	Таны амьдарч буй сууцны төрөл	Гэр	1		
		Сууцны тусдаа байшин	2		
		Бие даасан тохилог сууц	3		
		Орон сууцны байшин	4		
		Нийтийн байр	5		
		Бусад сууц	6		
Олон нийтийн санал бодол					
Бүтээн байгуулалт					
14	Та Хан-Уул дүүрэгт хэдэн жил амьдарч байна бэ?	6 сараас доош	1	16	
		6 сараас - 1 жил	2		
		1.1 - 3 жил	3		
		3-аас дээш жил	4		
15	Хан-Уул дүүрэгт сүүлийн 3 жилд хэрэгжсэн томоохон бүтээн байгуулалт, тохижилтын ажлыг нэрлэнэ үү.	1 Сургууль			
		2 Цэцэрлэг			
		3 Ахмадын эко сувилал			
		5 Нүхэн гарц			
		6 Туул голын дундын дугуйн зам			
		7 Бусад			
16	Таны амьдарч буй орчинд хүүхдийн тоглоом талбай байдаг уу?	Тийм	1	18	
		Үгүй	2		19
		Мэдэхгүй	3		
17	Таны амьдарч буй орчинд хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж хангалттай байдаг уу?	Маш хангалтгүй	1	1	
		Хангалтгүй	2		
		Дунд зэрэг	3		
		Хангалттай	4		
		Маш хангалттай	5		
18	Та хаана хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламжийг нэмэгдүүлмээр байна вэ?	1			
		2			
		3			
19	Таны амьдарч буй орчинд гэрэлтүүлэг байдаг уу?	Тийм	1	21	
		Үгүй	2		22
		Мэдэхгүй	3		
